



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А87

Улаанбаатар хот

Импортын лиценз олгох тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.1 дэх хэсэг, Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоол, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4.1.2, 4.1.3 дах хэсэг, Хүний эмийн зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 17-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь Нэгдсэн үндэсний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас хэрэгжүүлж байгаа Олон улсын хамтарсан хөтөлбөрт оролцох болсон тул судалгаа шинжилгээний зориулалтаар хэрэглэх мансууруулах 6, сэтгэцэд нөлөөт 9, бусад бүлгийн 6 бодист импортын нэг удаагийн лиценз олгосугай.

2. Импортын зөвшөөрөл олгох мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нэрийг нэгдүгээр, судалгаа шинжилгээнд хэрэглэх бусад бүлгийн бодисын нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодист нэг удаагийн импортын лиценз олгохыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Энхболд)-д, бусад бүлгийн бодист нэг удаагийн импортын лиценз олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-эрдэнэ)-д даалгасугай.

4. Импортоор хүлээн авсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ болон зарцуулалтын тайланг Эрүүл мэнд, спортын яаманд ирүүлэхийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн (Х.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080293

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 03 сарын 14 өдрийн
АА7 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



ИМПОРТЫН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ МАНСУУРУУЛАХ,
СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН НЭР

№	Бодисын олон улсын нэр /international non-proprietary name/	Тун хэмжээ/ Dosage	Хэмжих нэгж/Unit	Тоо хэмжээ/ Quantity
Мансууруулах бодис				
1	Cannabis oil	0.230 гр	vial	1ш
2	Cannabis plant	1.00 гр	vial	1ш
3	Cannabis resin	0.580 гр	vial	1ш
4	Cocaine	0.230 гр	vial	1 ш
5	Heroin	0.230 гр	vial	1 ш
6	Morphine	0.230 гр	vial	1 ш
Сэтгэцэд нөлөөт бодис				
1	Amfetamine	0.230гр	vial	1ш
2	N-Ethyl-methylenedioxyamfetamine / MDEA/	0.230 гр	vial	1ш
3	Metamfetamine	0.230 гр	vial	1ш
4	3,4-Methylenedioxyamfetamine /MDMA/	0.230 гр	vial	1ш
5	Δ 9- Tetrahydrocannabinol (delta-9-THC)	0.230 гр	vial	1ш
6	Ketamine	0.230 гр	vial	1ш
7	Lysergide (LSD)	0.0001 гр	vial	1ш
8	Nimetazepam	0.230 гр	vial	1ш
9	1-(3-chlorophenyl) piperazine	0.230 гр	vial	1ш

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 03 сарын 14 өдрийн
А17 дугаар тушаалын 2-дугаар
хавсралт



ИМПОРТЫН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
БУСАД БҮЛГИЙН БОДИСЫН НЭР

№	Бодисын олон улсын нэр /international non-proprietary name/	Тун хэмжээ/ Dosage	Хэмжих нэгж /Unit/	Тоо хэмжээ /Quantity
Бусад бүлгийн бодис				
1	Caffeine	0.230 гр	vial	1ш
2	Lactose	0.230 гр	vial	1ш
3	Lidocaine (Lignocaine)	0.230 гр	vial	1ш
4	Paracetamol (Acetaminophen)	0.230 гр	vial	1ш
5	Procaine	0.230 гр	vial	1ш
6	Mephedrone	0.230 гр	vial	1ш